



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

“Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэмд
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн хорооны 2012 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 364 дүгээр тогтоолоор баталсан “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 1.2, 4.1 дэх хэсэг, 4.2.4 дэх заалтыг дор дурдсанаар тус тус өөрчилсүгэй.

“1.2.Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь олон улсын жишигт нийцсэн орчин үеийн технологи, багаж, тоног төхөөрөмж, мэргэшсэн боловсон хүчний нөөцөд тулгуурлан байгаль орчин, цэнгэг усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, судалгаа шинжилгээ хийж, байгаль орчны төлөв байдлын талаар ашиглагч, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа, судалгааны ажил явуулах, мэргэжлийн болон хөндлөнгийн дүгнэлт гаргах, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагыг байгаль орчны мэдээллээр хангах, өсвөр залуу үе, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх үндсэн чиг үүрэг бүхий үйлдвэрийн газар мөн”

4.1.“Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Усны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах багц хууль тогтоомж, цэнгэг усны талаар баримтлах төрийн бодлого, хөтөлбөр, шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд байгаль орчны төлөв байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, байгалийн нөөц, ашиглалтад хяналт, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, мэргэжлийн байгууллагын шинжилгээ, дүгнэлтээр хөндлөнгийн хяналт хийх, судалгаа, сургалт, сурталчилгаа, хамгаалах ажлыг зохион байгуулах, байгаль орчны мэдээллийн санг баяжуулах, холбогдох мэдээллээр хангахад оршино.

4.2.4.Байгалийн нөөцийн төлөв байдал, чанарын шинжилгээ, судалгааны талаар мэдээллийн сан бүрдүүлэх.”

2. “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Даваажавт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн хорооны 2012 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 364 дүгээр тогтоолоор баталсан “Цэнгэг усны нөөц,

байгаль хамгаалах төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 1.2, 4.1 дэх хэсэг, 4.2.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-г даалгасугай.

| | | |
|---|--|---------------|
| ДАРГА |  | Б.ЦЭНГЭЛ |
| ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА |  | Ц.БАЯР-ЭРДЭНЭ |